

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**МОНГОЛ-ЯПОНЫ ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН
ХАРИЛЦАА****О. Оюунгэрэл**

Дэлхийн II дайнд зөвлөлтийн баатарлаг ард түмэн ялсны үр дүнд социалист систем үүсэн тогтсон явдал Монголын гадаад худалдааг хөгжүүлэх, баруун Европ, Азийн зарим орнуудтай худалдааны харилцаа тогтоох таатай нөхцөлийг бий болгосон юм.

Манай улс 50-иад оны эхэн хүртэл ЗХУ-тай худалдаа-эдийн засгийн харилцаа тогтоон ажиллаж дайны дараа манай улсын хувьд улс төр, эдийн засгийн талаар гадаад харилцаа өргөтгөх боломж бий болж 50-иад оны эхнээс 60-аад он хүртэл 11 социалист оронтой засгийн газрын хэмжээнд худалдааны хэлэлцээ байгуулж ажиллав.¹

БНМАУ 1961 онд НҮБ-д гишүүнээр элсэн орсноор манай улсын нэр хүнд дэлхий дахинаа улам өсч тус улсын энх тайванч гадаад бодлогын үрээр тэгш эрхийн үндсэн дээр харилцан ашигтай худалдаа эдийн засгийн харилцаа өргөжин хөгжив.

1961 онд ардын хувьсгалын 40 жилийн ойгоор БНАГУ, БНПАУ, Японд болсон олон улсын үзэсгэлэн яармагт БНМАУ гадаад худалдааг сурталчлан худалдаа хийсэн байна.

60-аад оноос эхлэн тэгш эрх, харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурлан БНМАУ-ын гадаад худалдааны нэгдлүүд, Швейцарь, Япон, Англи, Франц, Австри, Швед зэрэг зарим хөгжингүй капиталист гүрний пүүсүүдтэй худалдаа хийж эхэлжээ.

Эдгээрийн дотроос Монгол, Япон улсын хоорондох худалдаа, эдийн засгийн харилцаа нэлээд онцлог юм. Энэ үед албан ёсны дипломат харилцаа байгаагүй боловч, 50-иад оны дундуур БНМАУ Японтой ажил хэргийн хэлхээ харилцаа тогтоов. 1957 онд Бээжин хотноо хоёр улсаас албаны шугамаар ирсэн төлөөлөгчид хэлэлцээ хийж, ойрын үед худалдааны харилцаа тогтоох тухай баримт бичигт гарын үсэг зуран, харилцан бараа нийлүүлэх талаар хэлэлцэн тохиролцжээ.² Монгол улс Японд мал аж ахуйн бүтээгдэхүүн, ангийн үс, мод материалыг, Япон манай улсад эмнэлгийн багаж төхөөрөмж, эмийн зүйл, химийн бодис болон бусад барааг тус тус нийлүүлэх болов.

1959 оны 5-р сард БНМАУ-ын худалдааны байгууллагын төлөөлөгчид Токиод нээгдсэн олон улсын яармагийг үзэж, японы засгийн газрын албан ёсны төлөөлөгчид болон манай улстай худалдаа хийх сонирхолтой зарим байгууллагын хүмүүстэй уулзаж хэлэлцээ хийв. Үүний үр дүнд хоёр тал худалдааг Олон улсын худалдааг дэмжих Японы Ассоциацийн шугамаар явуулах, мөн худалдааны төлөөлөгчдийг солилцож байх тухай хэлэлцэн тохиролцжээ.

¹«БНМАУ-ын гадаад худалдааны хөгжилт» (60 жилд) УБ, 1981 х 25

²«Үнэн» 1957. XI. 4

Дайнаас хойш 1957 оны 7-р сард анх удаа Монголд «Мэйва» компанийн орлогч захирал тэргүүтэй японы худалдааны төлөөлөгчид хүрэлцэн ирэв. Эдгээр компани, БНМАУ-ын худалдааны байгууллагууд хоорондоо харилцан бараа нийлүүлэх тухай хэд хэдэн гэрээ контракт байгуулсан билээ.³

1959 оны 8-р сард Улаанбаатар хотноо хоёр тал 2 сая долларын хэмжээнд худалдаа хийх протоколд гарын үсэг зурснаар БНМАУ, Япон улсын хооронд худалдааны хэлэлцээ явагдаж эхэлсэн бөгөөд дээрх протоколд үндэслэн Олон улсын худалдааг дэмжих Японы Ассоциаци, БНМАУ-ын Гадаад Худалдааны яамны хооронд жил бүр худалдааны хэмжээг тохиролцож ирсэн юм.⁴ 1968 оноос эхлэн жил бүр худалдааны хэлэлцээ хийж протокол гарган ажиллах болов.

1963 онд Японд БНМАУ-ын худалдааны төлөөлөгчид хүрэлцэн очиж, «Монголэкспорт» нэгдлийн төлөөлөгчид Японы хэд хэдэн пүүстэй 500 мянга гаруй долларын хэмжээний худалдаа хийх контракт гарын үсэг зурав. Уг контрактын дагуу Монгол улс Японд адууны дэл сүүл, сарлагийн хөөвөр, ангийн үс, Япон манай улсад автомашины дугуй, сэлбэг эд болон барилгын материал, цахилгаан аппаратур зэргийг тус тус нийлүүлж байжээ.

Мөн оны 12-р сард Монголд Японы нэлээд хэдэн компанийг төлөөлсөн төлөөлөгчид ирж, монголын гадаад худалдааны нэгдлийн гишүүдтэй хэлэлцээ хийв. 1967 онд Олон улсын худалдааг дэмжих Японы Ассоциацийн урилгаар монголын төлөөлөгчид Японд хүрэлцэн очиж 1 сар байх хугацаандаа энэхүү Ассоциацид ордог байгууллагууд, БНМАУ-тай худалдаа хийх хүсэлтэй байдаг пүүсүүдтэй хэлэлцээ хийсэн байна. 1968 оны 3-р сард Токио хотноо монголын гадаад худалдааны байгууллагууд, ЗХУ, Европын социалист орнуудтай худалдаа хийх Японы Ассоциацитай 3 жилийн хугацаатай худалдааны хэлэлцээр байгуулж, жил бүрийн таваарын солилцоог 1 сая долларт хүргэхээр тохирсон билээ.⁵ Уг хэлэлцээрийн дагуу Япон улс монголын үслэг эд, вольфром болон янз бүрийн төрлийн түүхий эдийг (адууны дэл сүүл- малын яс, шир,) автомашины дугуй, радиотехник, бөс бараа зэрэг зарим өргөн хэрэгцээний зүйлийн оронд импортлох болжээ. Үүнээс гадна хоёр тал худалдаа-эдийн засгийн төлөөлөгчдийг солилцож байх тухай зүйлийг гэрээнд оруулжээ.

БНМАУ, Япон улс хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд харилцан ашиг сонирхолтой байгаагаар илэрхийлсэн билээ. Дашрамд тэмдэглэхэд, Японы улсын болон хувийн худалдааны байгууллагууд БНМАУ-тай худалдаа хийхийг сонирхдог болжээ. Киодо Цусин агентлагийн мэдээлснээс үзвэл, Японы 35 компани, пүүсүүд Монголтой худалдаа хийх хүсэлтэй байгаагаар мэдэгджээ.⁶ 1969 онд Монголтой худалдааны харилцааг өргөтгөх боломжийн талаархи асуудлыг судлаж байсан Японы Үндэсний парламентын төлөөлөгчид БНМАУ-д хүрэлцэн ирэв. Японд монголын барааны талаар эрэлт хэрэгцээ өсч, монголын зах зээлийг Японы бараа таваарыг худалдаалахад найдвартай гэж үзэж байв.

Хэрэв тус хоёр орны хоорондын бараа эргэлтийн хэмжээ 1965 онд 455 мянган доллар байсан бол 1966 ойд 570 мянган доллар, 1967 онд

³Е. В. Бойкова. Отношения МНР с капиталистическими и развивающимися странами. 60—70-е годы М, 1982. с 24—25

⁴Ёсида Минору. Монгору хаккэн. (Монголыг үзсэн нь), Токио, 1979, х. 50. (Япон хэл дээр)

⁵«Новости Монголии», 1968, III. 23

⁶ Мөн тэнд.

922 мянган доллар,⁷ 1970 онд 1250 мянган доллар болж өссөн байна. 60-аад оны сүүлээр Японы 40 орчим компани, пүүсүүд БНМАУ-тай худалдааны хэлхээ холбоо тогтоох эрмэлзлээ илэрхийлжээ.⁸

Худалдааны танхимын шугамаар 1970 онд ЗХУ, социалист орнуудтай худалдаа хийх Японы Ассоциацийн еронхийлөгчийг дагалдагсдын хамт Улаанбаатарт ирүүлж хоёр талын худалдааны цаашдын харилцааны талаар санал солилцов.⁹

70-аад оны эхээр БНМАУ, Япон улсын хоорондох худалдаа эдийн засгийн хэлхээ холбоо идэвхжиж, 1 сая долларт хүрч байгаад 1977 онд 2 сая 930 мянган доллар болсон нь хоёр улсын хооронд худалдааны харилцаа хөгжиснөөс хойших хамгийн том үзүүлэлт болов. 1979 онд манай экспорт 800 мянган доллар, импорт 520 мянган доллар байсан бол 1980 онд 786 мянган доллар, 546 мянган доллар болсон байна.

Хоёр талын нийт худалдааны хэмжээ одоо 1—2 сая ам. долларын хооронд хэлбэлзэж байна.

Хоёр орны хоорондох эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор 1972 оны 9-р сард Токио хотноо японы томоохон үйлдвэр, худалдааны пүүс болон банкны газрын төлөөлөгчид орсон япон-монголын эдийн засгийн зөвлөл, мөн оны 10-р сард Улаанбаатар хотод Японтой эдийн засгийн талаар хамтран ажиллах асуудал эрхэлсэн Монгол-японы комисс тус тус байгуулагджээ. Уг байгууллагууд нь Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Япон улсын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх тухай асуудлыг судлан хэлэлцэж, хоёр талаас эдийн засгийн төлөөлөгчдийг солилцох ажлыг явуулж иржээ.

1973 оны 3-р сарын 30-нд монголын худалдааны хэлэлцээр хийх төлөөлөгчид Японд хүрэлцэн очиж, Японоос зарим бараа авах тухай хэлэлцээ хийсэн байна. Түүнчлэн, Монголын засгийн газрын төлөөлөгчид 1973 оны 4-р сард Японд хүрэлцэн очиж, хоёр орны хооронд байгуулсан эдийн засгийн талаар хамтран ажиллах гэрээний дагуу хэд хэдэн үйлдвэрийн газарт очиж урьдчилсан судалгаа хийв. Ийм айлчлалууд нь урьд өмнөхөөс илүү үр дүнтэй болж байгааг японы тал тэмдэглэжээ.¹⁰

БНМАУ, Япон улсын хоорондох худалдаа, эдийн засгийн харилцаа сүүлийн жилүүдэд өргөжиж, экспортын барааны нэр төрөл олширч ирлээ.

70-аад онд Япон БНМАУ-д голчлон төрөл бүрийн химийн бүтээгдэхүүн (эмийн зүйл, будаг зэрэг) төмөрлөг эд, багаж хэрэгсэл, электрон болон цахилгаан-техникийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, оптикийн хэрэглэлийг; манай улс Японд адууны дэл сүүл, малын арьс, шир, ангийн үс ямааны ноолуур болон адууны мах зэрэг зүйлийг тус тус экспортод гаргаж байв.

1977 онд эдийн засгийн талаар хамтран ажиллах тухай хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш БНМАУ, Япон улсын хоорондын эдийн засгийн хэлхээ холбоо харьцангуй өсөв. Энэхүү хэлэлцээрээр Япон улс Монголд ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэр барих болов.

Улаанбаатарт ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах туршилтын үйлдвэрийг Япон улс НҮБ-ын хөгжлийн Програмын туслалцаатайгаар барьж өглөө. Одоо ноолуур боловсруулах технологийг

⁷«Үнэн» 1968. VIII. 30

⁸«Новости Монголии», 1969, III. 23.

⁹БНМАУ-ын гадаад худалдааны хөгжил. (60 жилд) УБ., 1981. х. 74.

¹⁰«Конничи-но Монгору» сонин (Япон хэл дээр) 1973, VII. 10. № 2.

эзэмших, монгол мэргэжилтнийг бэлтгэх ажилд Нэгдсэн Үндэсний Байгууллагын хөгжлийн Программ дэмжлэг үзүүлж байна.

1978 онд байгуулж эхэлсэн гол үйлдвэр болох «Говь» комбинат нь 1982 онд ашиглалтанд оров. Энэ нь үйлдвэрлэх өндөр хүчин чадлын тоног төхөөрөмжөөр хангагдсан орчин үеийн томоохон үйлдвэрийн нэг юм. VII таван жилийн эцэст уг үйлдвэр нь төслийн хүчин чадалдаа хүрч, жилдээ 1000 гаруй тонн ямааны ноолуур, 200 тонн тэмээний ноос боловсруулах болно.¹¹ Одоо манай улс «Говь» комбинатаас боловсруулж гаргасан ноос, ноолууран бүтээгдэхүүнийг ЗХУ, Герман, Унгар, Польш мөн Швейцари, Япон, Англи, Франц, Америк зэрэг дэлхийн олон арван оронд гаргаж байна.

Монгол улс хөрөнгөтөн оронтой эдийн засгийн хүрээнд харьцангуй бага хэмжээний худалдаа хийдэг бөгөөд 1978 оны монгол-японы худалдаа, эдийн засгийн хэлэлцээрээр Монгол улс анх удаа Японоос үйлдвэрийн тоног төхөөрөмж авах болов.

Японтой хийсэн манай улсын худалдаа 1980 оны байдлаар: японд адууны дэл сүүл, ямааны боловсруулсан ноолуур, хялгас зэрэг барааг гаргаж, ноос, нэхмэлийн үйлдвэрийн сэлбэг материал, жижиг цахилгаан станц, хувилах машин, тооны машин түүний сэлбэг, эмнэлгийн төхөөрөмж, эм, электрон хэрэгсэл, биеийн тамирын өргөн хэрэгцээний зарим барааг худалдан авчээ.¹²

Монгол, японы эдийн засгийн асуудал эрхэлсэн комисс, япон-монголын эдийн засгийн хорооны хамтарсан анхны хуралдаан 1980 оны 12-р сард Улаанбаатарт болов. Хамтарсан хуралдааны хэлэлцсэн асуудлаар протокол гаргав.¹³

Монгол-Япон улсын хооронд худалдааны харилцаа өсөн өргөжиж байна. Монголын экспорт, импорт нэгдэл Японы «Иточю Сёдзи», «Ниссё-иваи» «Номура-боэки», «Вако-боэки» зэрэг 20 орчим пүүстэй худалдаа хийж байна. Монголын талаас гол төлөв ямааны ноолуур, хонины ноос, үхрийн арьс шир, адууны дэл сүүл, төрөл бүрийн ангийн үс, бугын эвэр, эрдэнийн чулуу, японы талаас машин техник, автомашины дугуй, даавуу зэрэг бөс бараа нийлүүлж байна.

Одоо манай улс дэлхийн 30 гаруй улс орны олон зуун үйлдвэр, худалдааны байгууллага, пүүстэй худалдаа хийж, улс ардын аж ахуй, соёл, хүн амын хэрэгцээт хэдэн арван мянган нэр төрлийн барааг импортлон авч, өөрийн эх орны аж үйлдвэр, хөдөө аж ахуйн олон нэр төрлийн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээл дээр худалдан борлуулж байна. Цаашид ч хөрөнгөтөн оронтой мөн түүний дотор Япон улстай худалдааны өргөн салбарласан харилцааг нарийн бодож төлөвлөх, тэрчлэн тээврийн асуудлыг шийдвэрлэх явдал зүй ёсоор тавигдаж ирэх бөгөөд энэ нь улс хоорондын харилцан үр ашигтай худалдаа хийхэд багагүй ач ходбогдолтой юм.

Ер нь манай Монгол улс хөрөнгөтөн орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших зарчим, эрх тэгш, бие биеэ хүндэтгэх, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр эдийн засгийн хэлхээ холбоо, худалдааг өргөжүүлсээр ирсэн ба хойшид ч өргөжүүлэх болно. МАХН-ын XVIII их хуралд тавьсан тайлан илтгэлдээ, нөхөр Ю. Цэдэнбал хэлэхдээ: «БНМАУ

¹¹«Правда» 1983. III. 25.

¹² БНМАУ-ын гадаад худалдааны хөгжил (60 жилд) УБ., 1981, х, 101.

¹³«Үнэн», 1980. XII. 17.

капиталист орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр харилцаж байна. Австри, Их Британи, Финлянд, Франц, Япон зэрэг оронтой энэ үндсэн дээр худалдаа, эдийн засгийн харилцаа, соёлын солилцоо хөгжүүлж байна. БНМАУ цаашид ч эдгээр оронтой харилцан ашигтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэхийн төлөө байх бодно»¹⁴ гэжээ.

¹⁴ Ю. Цэдэнбал. МАХН-ын XVIII их хуралд тавьсан НТХ-ны тайлан, ойрын жилүүдийн зорилт, УБ. 1981. х. 23